

## АНУ-ЫН ХҮМҮҮНЛЭГ ТУСЛАМЖ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ

Р.Цэрэнхагва  
Эрүүл мэндийн яамны ажилтан

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн нөхцөлд улс орны нийгэм, эдийн засгийн хямралт байдалд орохоос шалтгаалан хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд зарим бэрхшээл учирч, хөдөлмөрчид, эмнэлэгийн байгууллага хэрэгцээт эм, эмнэлэгийн багаж хэрэгсэл, машин техникээр гачигдаж байна.

Хөрөнгийн боломжгүйгээс гадаад орнуудаас авахаар захиалсан эм хэрэглэлээ авч чадахгүй, зөвхөн зээл, тусдамжийн хөрөнгийн зарим хэсгээр өчүүхэн хэсгийг авч эмнэлэг үйлчилгээг залгуулж байна.

Эмнэлэг, хөдөлмөрчдийн хэрэгцээнд гаргаж буй эм, хэрэглэлийн 50 гаруй хувийг гадаад орнууд, олон улсын болон буяны байгууллагуудын хүмүүнлэг тусламжаар авч байна. Эдгээр тусламжийн дийлэнх хэсгийг АНУ-ын Засгийн газар, байгууллага, хувь хүмүүсээс ирүүлсэн тусламж эзэлж байгаа юм.

Өнгөрсөн онд АНУ-аас манай улсад олгосон буцалтгүй тусламжийн 1 сая доллараар эмнэлэг хөдөлмөрчдийн хэрэгцээнд эхний ээлжинд нэи шаардлагатай зарим эм, хэрэглэлийг Орос улс, Зүүн Европын орнуудаас худалдан авлаа. Сүүлийн 2 жилд АНУ-ын Батлах Хамгаалах Яамны тусламжийг 3 удаа авч, удаах ээлжийг авах мэдээ аваад байна.

1,5 сая долларын дээрх тусламжинд эмнэлэг, үйлчилгээнд чухал шаардлагатай ороох боох, материал, эмнэлэгийн хэрэглэл, зүү тавиур, зарим багаж хэрэглэл, эм, эмнэлэгийн түргэн тусламжийн автомашин багтаж байгаа юм.

Америкийн "Морисон Кнудсен" компаниас буцалтгүй тусламж болгож сая шахам долларын чухал эм, витамин, эмнэлэгийн хэрэглэлийг нийслэл хотын хүүхдийн эмнэлэгүүдэд хуваарилан, өөчтэй, сульдаатай хүүхдүүдийн хэрэгцээнд олгов.

АНУ-ын "Лайтхаус" пүүсийн урилга, зардлаар "Монголимпэкс" нэгдлийн ерөнхий захирал А.Ламжав тэргүүтэй төлөөлөгчид Вашингтон, Пе

нсийн хотын зарим эмнэлэг, эм хангамж, үйлдвэрлэл худалдааны байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, тус улсын хэрэгцээт зарим эм, хэрэглэлийг гадаад худалдаагаар авах боломжийг судлан, авах гэрээ байгуулж ирлээ.

Америкийн "Акилес Трак Клуб" гэдэг буяны байгууллага өөрийн зардлаар манай өвчтөн Туулыг хүлээн авч, түүнд нүдний эвэрлэг бүрхүүл шилжүүлэн суулгах мэс заслыг буяны эмнэлэгийн эмч Жон Сийдор үнэ төлбөргүй хийж, хараа оруулан, чин сэтгэлийн хүмүүнлэг тусламж үзүүлсэн юм.

АНУ-д төвтэй "Энхтайвны корпус" байгууллагын шугамаар Эрүүл мэндийн яаманд компьютерийн 2 багш, мэргэжилтэн, англи хэлний багш ирж хоёр жилийн хугацаатай ажиллаж байна. Тэд яамны аппаратын ажилтануудад компьютер болон англи хэлний сургалт явуулж, яаманд компьютерийн сүлжээ байгуулах ажилд тусалж байна. Мөн "Олон улсын дэмжлэг тусалцаа" байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж уг байгууллагаас 2 удаа нийтдээ 1,2 сая орчим ам. долларын эм, антибиотик, хүүхдийн тэжээл, витамин, эмнэлэгийн зарим тоног төхөөрөмжийг буцаалгүй тусламжаар авлаа.

АНУ-ын мэдээллийн агентлагийн зардлаар тус яамны ажилтан Г.Пүрэвсүрэн өнгөрсөн онд явж, хүүхдийн болон гэр бүл төлөвлөлт, эмгэг удамшлийн тусламжийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, туршлага судалж, мэргэжлээ дээшлүүлж ирэв.

Атланта хот дахь өвчний хяналтын төвийн мэргэжлийн байгууллагатай эх барих, эмэгтэйчүүд, эмгэг, удамшлийн тусламжийн талаар хамтран ажиллах харилцаа тогтоож, Жорж муж улсын Огасто хотын Анагаах ухааны их сургуулийн доктор Атонио Милучи Монгол улсад ирж эхийн хэвдэй дэх үрийн оношлогооны тасгийг Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд байгуулах талаар урьдчилсан судалгаа хийгээд байна.

АНУ-ын үндэсний эрүүл мэндийн хүрээлэн, өвчний хяналтын төвийн урилгаар Эрүүл мэндийн яамны сайд П.Нямдаваа айлчилж, эдгээр байгууллагуудтай холбоо тогтоож, дэлхийн хүн амын өвчлөл, анагаах ухааны эрдэм шинжилгээ, эрүүлийг хамгаалахын талаар үнэ төлбөргүй мэдээлэл, материал болон хавдар судлалын талаарх лэзэрийн дискийн бичлэгийг авч байгаагийн зэрэгцээ, Америкийн нэртэй эрдэмтэд, эмч нар өөрсдийн зардлаар ирж, ажилд зохих хэмжээний зарим тусалцаа үзүүлж байна.

АНУ-ыг Үндэсний эрүүл мэндийн хүрээлэн, Монгол улсын эрүүл мэндийн яамны хооронд ангаах ухаан, эрүүлийг хамгаалахын салбарт хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулж, Америкийн талд хүргүүлээд байна.

АНУ-ын Нью-Йорк хотод төвлөрдөг Олон улсын Орбис байгууллагын нисдэг эмнэлэг өөрийн бүрэлдэхүүнээр Улаанбаатар хотод 2 дахь удаагаа ирж, манай нүдний өвчин эмгэгт нэрвэгдсэн хүмүүсийг үнэ төлбөргүй оношилж эмчлэн, нүдний эмч, сувиллагчид сургалт явуулан хүмүүнлэг энэрэнгүй тусламж үзүүллээ.

Сүүлийн хоёр жилд АНУ-тай эрүүл мэндийн салбарт хамтран ажилласан туршлагаас үзэхэд цаашид түүнийг өргөжүүлж, үр бүтээлтэй хамтын ажиллагаа тогтоох боломж нээж байгаа юм.